



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 2/461

Хэрлэн сум

Албан уулзалтад оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн Газрын 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 190 дүгээр тогтоолын “Монгол Улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймаг дахь Монгол банкны захирал Дэрийлаагийн Болортунгалагыг 2023 оны 10 дугаар сарын 02-оос 2023 оны 10 дугаар сарын 08-ны хооронд Япон Улсын Токушима хотын захиргаанаас зохион байгуулагдах хамтын ажиллагааны уулзалтанд оролцуулсугай.

2.Энэхүү уулзалтад оролцох бэлтгэлийг ханган ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн дарга (Ч.Баярцолмон)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ